

ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ТӨСВИЙН ШУУД ЗАХИРАГЧ

АУДИТЫН КОД: ТӨА-2022/06/-НА-СТА-ТШЗ

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
ДӨРВӨН ЗУУН АРВАН ДОЛОО ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ АНГИЙН
2021 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН
САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

Зуунмод 2022 он



Аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал

Утас: 70272582 Цахим хаяг: khishigjargalts@audit.gov.mn

Аудитын менежер О.Амаржаргал

Утас: 70273463 Цахим хаяг: amarjargalo@audit.gov.mn

Аудитор Т.Хүрэлбаатар

Утас: 70272248 Цахим хаяг: khurelbaatar@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу. Цахим хаяг: www.audit.mn

Агуулга

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл	4
2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан.....	4
2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан	9
2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан	10
2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан	14
3. Аудитын тайлан	16
3.1 Ерөнхий зүйл	16
3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт	16
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал.....	17
3.4 Материаллаг байдал.....	17
3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга	18
3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	19
3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг	20
3.8 Аудитын гол асуудал.....	20
3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	20
3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	20
3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	21
3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал	21
4. Аудитын илрүүлэлт.....	21
4.3 Албан шаардлага.....	22

Товчилсон үгийн жагсаалт

УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
ТӨБЗГ	Төрийн Өмчийн Бодлого Зохицуулалтын Газар
ШШГЕГ	Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газар



**ТӨВ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

41100 Зуунмод, Төв аймаг
Утас: 70272248, Факс: 70272582, И-мэйл: tuv@audit.gov.mn

2022.02.25 № 01/61
танай _____ -ны № _____ -т

ШҮҮХИЙН ШИЙДВЭР ГҮЙЦЭТГЭХ
ЕРӨНХИЙ ГАЗРЫН ХАРЬЯА
ДӨРВӨН ЗУУН АРВАН ДОЛОО
ДУГААР НЭЭЛТТЭЙ ХОРИХ
АНГИЙН ДАРГА, ДЭД ХУРАНДАА
О.НЯМБААТАР ТАНАА

Зөрчилгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторовын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, шалгагдагч этгээдээс хараат бус, аудиторовын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт гэдэг нь дээд түвшний баталгаа боловч материаллаг буруу илэрхийлэл байгаа тохиолдолд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүгдийг илрүүлнэ гэсэн баталгаа биш юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гаргах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР



Ц.ХИШИГЖАРГАЛ
19020246

D 2022/2022 он/ALBAN BICHIG

2.Аудит хийсэн санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэл

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	<u>247,215,785.90</u>	<u>161,022,634.32</u>
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	13,977,455.20	5,589,252.20
312	Банкинд байгаа бэлэн мөнгө	13,977,455.20	5,589,252.20
3121	Төгрөг	13,977,455.20	5,589,252.20
31211	Төрийн сангийн харилцах	13,977,455.20	5,589,252.20
33	АВЛАГА	13,545,287.20	7,916,935.78
33300	Татаас, санхүүжилтийн авлага	9,186,211.20	-
335	Бусад авлага	4,359,076.00	7,916,935.78
3351	Байгууллагаас авах авлага	4,359,076.00	7,916,935.78
35	БАРАА МАТЕРИАЛ	219,693,043.50	147,516,446.34
351	Түүхий эд материал	41,239,155.76	42,110,282.76
35110	Тусгай зориулалттай материал	37,910,348.56	39,322,918.56
35130	Эм боох материал	3,328,807.20	2,787,364.20
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	82,321,877.39	-
35300	Бэлэн бүтээгдэхүүн	11,694,082.37	19,891,791.84
354	Хангамжийн материал	54,034,927.98	35,419,371.74
35410	Бичиг хэргийн материал	5,614,506.23	7,680,870.23
35420	Аж ахуйн материал	29,505,079.60	15,662,279.00
35430	Сэлбэг хэрэгсэл	45,000.00	-
35440	Түлш, шатах тослох материал	281,398.40	2,031,000.00
35450	Барилгын засварын материал	6,178,547.35	1,893,927.35
35460	Хүнсний материал	9,968,846.40	4,391,135.00
35470	Бусад хангамжийн материал	2,441,550.00	3,760,160.16
35600	Мал амьтад	30,403,000.00	50,095,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	<u>1,253,133,586.81</u>	<u>1,350,785,633.03</u>
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	1,253,133,586.81	1,350,785,633.03
392	Биет хөрөнгө	845,105,603.13	942,997,393.03
39201	Барилга, байгууламж, орон сууц	910,333,449.46	1,047,190,289.74
39202	Хуримтлагдсан элэгдэл	(175,168,547.20)	(231,375,636.06)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	222,320,900.00	222,320,900.00
39204	Хуримтлагдсан элэгдэл	(185,635,344.65)	(198,875,066.73)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	115,448,771.94	168,507,951.25
39206	Хуримтлагдсан элэгдэл	(70,037,258.32)	(92,019,789.42)
39207	Тавилга, аж ахуйн эд хогшил	11,844,633.53	12,616,273.53
39208	Хуримтлагдсан элэгдэл	(5,909,001.63)	(7,275,529.28)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	21,908,000.00	21,908,000.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

393	Биет бус хөрөнгө	408,027,983.68	407,788,240.00
39301	Програм хангамж	4,987,692.31	4,987,692.31
39302	Хуримтлагдсан элэгдэл	(4,747,948.63)	(4,987,692.31)
39303	Бусад биет бус хөрөнгө	407,788,240.00	407,788,240.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	<u>1,500,349,372.71</u>	<u>1,511,808,267.35</u>
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	<u>27,443,491.23</u>	<u>36,242,325.20</u>
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	27,443,491.23	36,242,325.20
413	Өглөг	27,443,491.23	36,242,325.20
41310	Ажилчидтай холбогдсон өглөг	9,106,960.03	-
4136	Бусад өглөг	18,336,531.20	36,242,325.20
41361	Байгууллагад төлөх өглөг	-	27,560,000.00
41362	Хувь хүмүүст төлөх өглөг	18,336,531.20	8,682,325.20
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	<u>1,472,905,881.48</u>	<u>1,475,565,942.15</u>
51	Засгийн газрын хувь оролцоо	1,472,905,881.48	1,475,565,942.15
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	535,534,497.85	535,534,497.85
51101	Өмч: - төрийн	535,534,497.85	535,534,497.85
512	Хуримтлагдсан үр дүн	191,393,905.21	199,762,782.51
51210	Өмнөх үеийн үр дүн	389,423,476.47	197,102,721.84
51220	Тайлант үеийн үр дүн	(198,029,571.26)	2,660,060.67
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	745,977,478.42	740,268,661.79
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	<u>1,500,349,372.71</u>	<u>1,511,808,267.35</u>

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	895,097,033.39	1,031,108,186.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	133,536,633.39	237,594,386.46
120	Нийтлэг татварын бус орлого	133,536,633.39	237,594,386.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	133,536,633.39	237,494,386.46
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	69,948,808.04	122,483,036.58
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	63,587,825.35	115,011,349.88
120009	Бусад орлого		100,000.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	761,560,400.00	793,513,800.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	761,560,400.00	782,610,800.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	761,560,400.00	782,610,800.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	10,903,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө		903,000.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	1,093,126,604.65	1,025,797,343.99
21	УРСГАЛ ЗАРДАЛ	1,093,126,604.65	1,025,797,343.99
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	1,061,985,372.72	985,948,177.59
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	564,274,859.82	581,267,744.83
210101	Үндсэн цалин	369,748,759.82	353,815,544.88
210102	Нэмэгдэл	193,526,100.00	225,244,199.95
210104	Урамшуулал	1,000,000.00	2,208,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,675,800.21	10,436,741.89
210201	Тэтгэврийн даатгал	644,395.54	
210202	Тэтгэмжийн даатгал	64,439.52	
210203	ҮОМШӨ-ний даатгал	80,549.46	
210204	Ажилгүйдлийн даатгал	16,109.86	
210205	Эрүүл мэндийн даатгал	10,870,305.83	10,436,741.89
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	74,329,312.79	67,025,900.00
210301	Гэрэл, цахилгаан	52,583,982.21	53,725,300.00
210302	Түлш, халаалт	21,155,330.58	12,846,000.00
210303	Цэвэр, бохир ус	590,000.00	454,600.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	90,417,792.87	47,843,736.22
210401	Бичиг хэрэг	2,498,630.80	1,517,737.00
210402	Тээвэр, шатахуун	13,922,874.90	15,771,398.40
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,663,265.20	1,604,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,000.00	40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	461,367.00	607,881.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	24,132,424.75	25,437,319.82
210408	Бараа материал актальсны зардал	47,699,230.22	2,865,000.00
2105	Нормативт зардал	168,564,555.70	127,542,081.49
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,271,137.74	7,727,319.00
210502	Хоол, хүнс	138,439,426.36	112,459,323.09
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	23,853,991.60	7,355,439.40
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	27,983,083.00	15,018,844.05
210601	Багаж, техник, хэрэгсэл	10,897,328.00	5,392,840.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл		230,000.00
210604	Урсгал засвар	17,085,755.00	9,396,004.05
2107	Томилолт, зочны зардал	-	500,000.00
210702	Дотоод албан томилолт		500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,710,737.46	8,362,857.44
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	5,573,048.66	6,370,287.44
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	847,500.00	587,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	151,000.00	401,070.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	554,500.00
210807	Газрын төлбөр	139,188.80	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	117,029,230.87	127,950,271.67
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	2,782,550.00	15,275,550.10
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	280,046.00	
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	113,966,634.87	112,674,721.57
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,141,231.93	39,849,166.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,802,800.00	10,586,800.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,802,800.00	10,586,800.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,250,000.00	7,888,000.00
213209	Нэг удаагийн гэтгэмж, шагнал урамшуулал	1,250,000.00	7,888,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	88,431.93	1,374,366.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	88,431.93	1,374,366.40

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих
ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,000,000.00	20,000,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,000,000.00	20,000,000.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(198,029,571.26)	5,310,842.47
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	-	2,650,781.80
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз		2,650,781.80
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145- 225)	-	(2,650,781.80)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(198,029,571.26)	2,660,060.67

2.3 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Бусад	Засгийн газрын хувь оролцооны нийт дүн
C01	2019 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,534,497.85	748,938,082.89	386,462,872.00		1,670,935,452.74
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	2,960,604.47		2,960,604.47
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535,534,497.85	748,938,082.89	389,423,476.47	0.00	1,673,896,057.21
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	0.00	-2,960,604.47	0.00		-2,960,604.47
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	0.00	0.00	0.00		0.00
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
C07	Тайлант үеийн үр дүн			-198,029,571.26		-198,029,571.26
C08	2020 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,534,497.85	745,977,478.42	191,393,905.21	0.00	1,472,905,881.48
D01	2021 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	535,534,497.85	743,016,873.95	-6,635,666.05	0.00	1,472,905,881.48
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	0.00	0.00	5,708,816.63		5,708,816.63
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	535,534,497.85	745,977,478.42	197,102,721.84	0.00	1,478,614,698.11
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	0.00	-5,708,816.63	0.00		-5,708,816.63
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	0.00	0.00	0.00		0.00
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	0.00	0.00	0.00		0.00
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү					0.00
D08	Тайлант үеийн үр дүн			2,660,060.67		2,660,060.67
D09	2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	535,534,497.85	740,268,661.79	199,762,782.51	0.00	1,475,565,942.15

2.4 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ		
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	910,070,649.87	1,101,330,350.78
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	157,784,893.00	243,630,339.58
120	Нийтлэг татварын бус орлого	157,784,893.00	243,630,339.58
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	157,784,893.00	235,232,336.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	157,784,893.00	235,232,336.58
120009	Бусад орлого	-	8,398,003.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	752,285,756.87	857,700,011.20
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	752,285,756.87	791,797,011.20
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	752,285,756.87	782,610,800.00
131009	Оны эхний үлдэгдлээс санхүүжих	-	9,186,211.20
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	-	65,903,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,гүүнтэй адилтгах ангилалдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	55,903,000.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	902,630,102.77	1,098,799,504.47
21	УРСГАЛ ЗАРДАЛ	902,630,102.77	1,098,799,504.47
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	871,577,302.77	1,031,547,238.07
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	556,004,000.00	588,547,814.58
210101	Үндсэн цалин	361,477,900.00	361,095,614.63
210102	Нэмэгдэл	193,526,100.00	225,244,199.95
210104	Урамшуулал	1,000,000.00	2,208,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	10,839,700.00	11,433,283.75
210205	Эрүүл мэндийн даатгал	10,839,700.00	11,433,283.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	69,620,982.21	66,342,700.00
210301	Гэрэл, цахилгаан	52,583,982.21	53,725,300.00
210302	Түлш, халаалт	15,337,000.00	11,144,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,700,000.00	1,473,400.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2104	Хангамж, бараа материалын зардал	20,083,700.00	21,876,200.00
210401	Бичиг хэрэг	1,718,700.00	1,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	15,773,200.00	18,151,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,851,200.00	1,604,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,000.00	40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	700,600.00	780,600.00
2105	Нормативт зардал	109,580,700.00	105,230,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,580,700.00	5,996,600.00
210502	Хоол, хүнс	104,000,000.00	99,233,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	9,215,980.00	63,338,527.00
210601	Багаж, техник, хэрэгсэл	5,545,080.00	4,345,500.00
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,170,900.00	1,170,900.00
210604	Урсгал засвар	2,500,000.00	57,822,127.00
2107	Томилолт, зочны зардал	-	500,000.00
210702	Дотоод албан томилолт	-	500,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	89,623,740.56	93,583,201.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	87,486,051.76	91,590,631.54
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	847,500.00	851,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	151,000.00	137,070.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	554,500.00
210807	Газрын төлбөр	139,188.80	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,608,500.00	80,695,511.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,967,500.00	80,140,011.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	641,000.00	555,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	31,052,800.00	67,252,266.40
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	9,802,800.00	10,549,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	9,802,800.00	10,549,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	1,250,000.00	7,888,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	1,250,000.00	7,888,000.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	-	471,366.40
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	-	471,366.40
2135	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг	20,000,000.00	48,343,000.00
213503	Төвлөрүүлэх шилжүүлэг	20,000,000.00	48,343,000.00

3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	7,440,547.10	2,530,846.31
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	10,919,049.31
22	ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ	-	10,919,049.31
2200	Дотоод эх үүсвэрээр	-	10,919,049.31
225102	Биет бус хөрөнгө олж эзэмшихэд төлсөн /ТӨҮГ/		10,919,049.31
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	-	(10,919,049.31)
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	7,440,547.10	(8,388,203.00)
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	6,536,908.10	13,977,455.20
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	13,977,455.20	5,589,252.20

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Эдийн засгийн н	Үзүүлэлт	Тайлант оны	
		Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл
1	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		
2	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	898,618,800.00	1,060,904,187.38
21	УРСГАЛ ЗАРДАЛ	898,618,800.00	1,060,904,187.38
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	887,312,900.00	1,042,466,287.38
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	588,855,800.00	588,547,814.58
210101	Үндсэн цалин	361,403,600.00	361,095,614.63
210102	Нэмэгдэл	225,244,200.00	225,244,199.95
210104	Урамшуулал	2,208,000.00	2,208,000.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	11,794,800.00	11,433,283.75
210205	Эрүүл мэндийн даатгал	11,794,800.00	11,433,283.75
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	66,342,700.00	66,342,700.00
210301	Гэрэл, цахилгаан	53,725,300.00	53,725,300.00
210302	Түлш, халаалт	11,144,000.00	11,144,000.00
210303	Цэвэр, бохир ус	1,473,400.00	1,473,400.00
2104	Хангамж, бараа материалын зардал	21,876,200.00	21,876,200.00
210401	Бичиг хэрэг	1,300,000.00	1,300,000.00
210402	Тээвэр, шатахуун	18,151,200.00	18,151,200.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	1,604,400.00	1,604,400.00
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	40,000.00	40,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	780,600.00	780,600.00
2105	Нормативт зардал	105,230,000.00	105,230,000.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,996,600.00	5,996,600.00
210502	Хоол, хүнс	99,233,400.00	99,233,400.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	76,903,000.00	74,257,576.31
210601	Багаж, техник, хэрэгсэл	15,265,500.00	15,264,549.31
210603	Хөдөлмөр хамгааллын хэрэглэл	1,170,900.00	1,170,900.00
210604	Урсгал засвар	60,466,600.00	57,822,127.00
2107	Томилолт, зочны зардал	500,000.00	500,000.00
210702	Дотоод албан томилолт	500,000.00	500,000.00

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудит

2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	9,301,100.00	93,583,201.54
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,146,100.00	91,590,631.54
210802	Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох	300,000.00	300,000.00
210804	Тээврийн хэрэгслийн татвар	851,000.00	851,000.00
210805	Тээврийн хэрэгслийн оношлогоо	154,000.00	137,070.00
210806	Мэдээлэл, технологийн үйлчилгээ	700,000.00	554,500.00
210807	Газрын төлбөр	150,000.00	150,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	6,509,300.00	80,695,511.20
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	5,953,800.00	80,140,011.20
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	555,500.00	555,500.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	11,305,900.00	18,437,900.00
2131	Засгийн газрын урсгал шилжүүлэг	10,549,900.00	10,549,900.00
213101	Засгийн газрын дотоод шилжүүлэг	10,549,900.00	10,549,900.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	756,000.00	7,888,000.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	756,000.00	7,888,000.00
	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	898,618,800.00	1,018,314,502.98
1310	УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	782,610,800.00	783,082,166.40
131001	Улсын төсвөөс санхүүжих	782,610,800.00	783,082,166.40
120004	ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	116,008,000.00	235,232,336.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	116,008,000.00	235,232,336.58
4	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл		13,977,455.20
5	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл		5,589,252.20

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	65,000,000.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	65,000,000.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	65,000,000.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	65,000,000.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	65,000,000.00
2133	Олгосон санхүүжилт, шилжүүлэг	903,000.00
213503	Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, төвлөрүүлэх шилжүүлэг	903,000.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	65,903,000.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	65,903,000.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	10,000,000.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	55,903,000.00
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	13,977,455.20
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	5,589,252.20

3. Аудитын тайлан

3.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана.” гэж заасны дагуу Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд шалгагдагч этгээд, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын талаар болон аудитын явцад илрүүлсэн алдаа, зөрчил, гаргасан шийдэл, анхаарал татахуйц бусад чухал асуудал болон аудитын санал дүгнэлт, түүний үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Энэхүү тайланд шалгагдагч этгээдэд төсвийн төлөвлөлт, худалдан авалттай холбоотой өгсөн зөвлөмжүүдийг тусгасан болно.

Аудитыг Төв аймаг дахь Төрийн аудитын газрын аудитор Т.Хүрэлбаатар гүйцэтгэж, хяналтыг аудитын менежер О.Амаржаргал, дарга, тэргүүлэх аудитор Ц.Хишигжаргал нар тус тус хэрэгжүүлсэн.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 01/55 дүгээр албан бичгээр ирүүлсэн байна.

3.2 Байгууллага, түүний орчин ба дотоод хяналт

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих анги нь шүүхийн шийдвэрийг нэг мөр гүйцэтгэж, цагдан хорих, баривчлах болон хорих ял эдлүүлэх үйл ажиллагааг олон улсын жишгийн түвшинд хуулийн хүрээнд зохион байгуулах, эд хөрөнгийн холбогдолтой шийдвэр бүрийн биелэлтийг хангах, үйлчлүүлэгч, хэрэглэгчид шуурхай үйлчлэх зорилго бүхий байгууллага юм.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн тайлант хугацаанд байгууллагын үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт ороогүй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн удирдлагын хэрэгжүүлж байгаа дотоод хяналтуудаас төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг авч үзэж, гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил гүйцэтгэсний үр дүнд дотоод хяналтын үйл ажиллагааны зохион байгуулалт, хэрэгжилт үр нөлөөтэй байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн мөрдөж байгаа Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичиг нь холбогдох хууль тогтоомж, нягтлан бодох бүртгэлийн стандартад нийцсэн, тус байгууллагын үйл ажиллагааны онцлогт тохирсон байна.

Тус ангид дотоод хяналт шалгалт явуулах ажлын хэсгийг ангийн даргын 2021 оны 01 дүгээр сарын 07-ний өдрийн а/11 дүгээр тушаалаар томилж, дотоод хяналт шалгалтын 14 чиглэлээр хийхээр төлөвлөгөө гарган 2021 онд төлөвлөгөөний дагуу ангийн даргын тушаалаар 9, удирдамжаар 3 удаагийн дотоодын хяналт шалгалтыг хийж ажилласан ба “Нууцын баримт бичгийн хадгалалт, хамгаалалт хууль тогтоомжийн хүрээнд явагдаж буй эсэхийг шалгах” дотоод хяналт шалгалт 2021 оны 10 дугаар сард хийгдэх байсан боловч тус ангийн нууц хамгаалах ажилтан, ахлах төлөөлөгч, ахмад Ц.Баттулга өвчний учир эмчийн магадалгаа авч, үргэлжлүүлэн ээлжийн амралтыг 2021 оны 12 дугаар сарын 10-ны өдөр хүртэл авсан тул дотоод хяналт шалгалтыг 2021 оны 12 дугаар сарын 15-ны өдөр хүртэл хойшлуулсан. Төлөвлөгөөний дагуу дотоод хяналт шалгалт 13 нэгжид хийгдэж 93,8 хувьтай биелэгдсэн байна.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн дотоод аудитын чиг үүрэг, түүний гүйцэтгэсэн ажлын найдвартай байдлын талаар ойлголт олж авснаар дотоод аудитын гүйцэтгэсэн ажлыг аудитад ашиглах, дотоод аудитораас шууд туслалцаа авах шаардлагагүй гэж үзлээ.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор санал дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккруз сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн хүлээн зөвшөөрөхүйц санхүүгийн тайлагналын үзэл баримтлал гэж үнэлсэн.

3.4 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр санхүүгийн үр дүнгийн тайлангийн нийт зарлагыг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэл “дунд” гэж үнэлэн материаллаг байдлын түвшинг 1.5 хувиар тогтоов.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2020 оны санхүүгийн тайлангийн нийт орлогын 1,031,108.1.4 мянган төгрөгөөс 1.5 хувиар буюу 15,466.6 мянган төгрөгөөр, гүйцэтгэлийн материаллаг байдлыг төлөвлөлтийн материаллаг байдлын 80 хувиар буюу 12,373.3 мянган төгрөгөөр тогтоосон.

Гүйцэтгэлийн үе шатанд гүйцэтгэлийн материаллаг байдлыг өөрчлөлгүй 12,373.3 мянган төгрөгөөр тогтоосон.

3.5 Санхүүгийн тайлангийн тодруулга

Энэхүү Санхүүгийн тайлангаар Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн 2021 оны санхүүгийн байдал, үйл ажиллагааны үр дүнг толилуулж байна. Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.3, 4.4 дэх заалтыг үндэслэн Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт (УСНББОУС) болон Монгол Улсын холбогдох хууль, журам, заавар, Шүүхийн шийдвэр гүйцэтгэх байгууллагын мөрдөгдөх Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн санхүүгийн тайланг бэлтгэсэн байна.

Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартад шаардсан зарчмын дагуу нягтлан бодох бүртгэлийн аккруэл сууриар бэлтгэн тайлагнасан байна.

Орлого:

Тус байгууллага 2021 онд улсын төсвөөс 782,610.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлого 122,483.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй хүлээн авсан орлого 115,011.3 мянган төгрөг, бусад орлого 100.0 мянган төгрөг, нэмэлт санхүүжилтийн дансанд 10,903.0 мянган төгрөг, нийт 1,031,108.1 мянган төгрөг, өмнөх оноос 136,011.1 мянган төгрөгөөр буюу 15.2 хувиар өссөн байна. Энэ нь нэмэлт санхүүжилтийн орлоготой холбоотой байна.

Зардал:

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих анги нь 2021 оны санхүүгийн тайлангийн үр дүнгийн тайлангаар 1,025,797.3 мянган төгрөг, мөнгөн гүйлгээний тайлангаар 1,098,799.5 мянган төгрөг, төсвийн гүйцэтгэлийн тайлангаар 1,060,904.1 мянган төгрөг зарцуулсан байна.

Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгө:

Тус байгууллага төрийн сангийн 100141512001 тоот дансанд 2021 онд 112,988.0 мянган төгрөгийн орлого, 112,988.0 мянган төгрөгийн зарлагын гүйлгээ хийгдэж, 2021 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн үлдэгдэл 0 төгрөг байна. Нэмэлт санхүүжилтийн 100141512401 тоот дансанд 65,903.0 мянган төгрөгийн орлого, зарлагын гүйлгээ хийгдэж үлдэгдэл 0 төгрөг байна. Ахмадын сангийн 100141512502 тоот дансанд 8,298.0 мянган төгрөгийн орлого орж, 7,132.0 мянган төгрөгийн зарлага гарч, үлдэгдэл 1,266.0 мянган төгрөг байна. Ялтны нэрийн 100141512501 тоот дансны эхний үлдэгдэл 13,977.4 мянган төгрөг, орлого 75,638.3 мянган төгрөг, зарлага 85,292.5 мянган төгрөг, эцсийн үлдэгдэл 43,323.2 мянган төгрөг байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	/мян.төгрөг/ Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Мөнгөн хөрөнгө	13,977.4	5,589.2	-8,388.2
Авлага	13,545.2	7,916.9	-5,628.3
Урьдчилгаа			
Бараа материал	219,693.0	147,516.4	-72,176.6

Үндсэн хөрөнгө	1,253,133.5	1,350,785.6	97,652.1
Нийт хөрөнгө	1,500,349.3	1,511,808.2	11,458.9
Өр төлбөр	27,433.5	36,242.3	8,808.8
Засгийн газрын оролцоо /Эздийн өмч/	1,472,905.8	1,475,565.9	2,660.1
Нийт өр төлбөр ба цэвэр хөрөнгө өмчийн дүн	1,500,349.3	1,511,808.2	11,458.9

Мөнгөн хөрөнгийн дансны үлдэгдэл 5,589.2 мянган төгрөг болж буурсан нь ялтны нэрийн дансны үлдэгдэлтэй холбоотой байна.

Авлага дансны үлдэгдэл 7,916.9 мянган төгрөгийн үлдэгдэл нь Багануур НИК салбар, Тулга проспек ХХК, НДШ-ийн авлагууд байна.

Бараа материалын дансны үлдэгдэл 147,516.4 мянган төгрөг болж 72,176.6 мянган төгрөгөөр буурсан нь бараа материалын бууралттай холбоотой байна.

Үндсэн хөрөнгө дансны үлдэгдэл 1,350,785.6 мянган төгрөг болж 97,652.1 мянган төгрөгөөр өссөн нь үнэ төлбөргүй авсан хөрөнгөтэй холбоотой байна.

Үндсэн хөрөнгийн данс нь урсгал төсвийн худалдан авалтаар 10,919.0 мянган төгрөг, үнэ төлбөргүй шилжиж ирсэн 202,058.5 мянган төгрөг, нийт 212,977.5 мянган төгрөгөөр нэмэгдсэн байна.

Засгийн газрын оролцоо дансны үлдэгдэл 1,475,565.9 мянган төгрөг болж 2,660.1 мянган төгрөгөөр өссөн нь тайлант үеийн үр дүнгээс шалтгаалжээ.

3.6 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн 5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.6.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2021 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг 1,200,807.1 мянган төгрөгөөр, бараа үйлчилгээний нийт зарлагыг 1,200,807.1 мянган төгрөгөөр тооцон төлөвлөж, дээд шатны төсвийн захирагчид хүргүүлсэн байна.

Төсвийн захирагчийн хүргүүлсэн төсвийн төслийг 418,196.3 мянган төгрөгөөр багасгаж улсын төсвөөс 782,610.8 мянган төгрөг, туслах үйл ажиллагааны орлогоос 116,008.0 мянган төгрөгөөр санхүүжүүлэхээр баталсан байна. Энэ нь цалин, НДШ, хангамж бараа материалын зардал, нормативт зардал, бусдаар гүйцэтгүүлсэн ажил үйлчилгээний зардлыг бууруулж баталсантай холбоотой байна.

3.6.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 2 хөтөлбөрийн 4 арга хэмжээг санхүүжүүлэхээр 898,618.8 мянган төгрөгийн төсөв баталснаас 782,610.8 мянган төгрөгийг улсын төсвөөс, 116,008.0 мянган төгрөгийг туслах үйл ажиллагааны орлогоор санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 782,610.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлого 112,988.0 мянган төгрөг нийт 895,598.8 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, урсгал үйл ажиллагаанд 846,784.5 мянган төгрөгийг зарцуулж, ШШГЕГ-т орлогын төлөвлөгөө болон төслийн зээлийн эргэн төлөлтөд 48,343.0 мянган төгрөг, оны эцэст зарцуулаагүй 471.3 мянган төгрөгийг улсын төсөвт буцаан төвлөрүүлсэн байна.

Төсвийн нийт зардлын гүйцэтгэл 895,127.4 мянган төгрөг буюу 99,6 хувьтай байгаа нь урсгал засварын зардлын зарцуулаагүй үлдэгдэлтэй холбоотой байна.

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.6.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих анги тайлант онд ШШГЕГ-аас 55,903.0 мянган төгрөг, Аймгийн засаг даргаас 10,000.0 мянган төгрөг, нийт 65,903.0 мянган төгрөгийн орлого орж, 55,000.0 мянган төгрөгийг зарцуулж, 903.0 мянган төгрөгийг төвлөрүүлсэн байна.

Ахмадын санд 8,298.0 мянган төгрөгийн орлого орж, 7,132.0 мянган төгрөгийг зарцуулж, оны эцсийн үлдэгдэл 1,266.0 мянган төгрөг байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.7 Асуудлыг онцолсон хэсэг ба бусад асуудлын хэсэг

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих ангийн ялтны нэрийн дансны үлдэгдэл 8,682.3 мянган төгрөг нь 104 ялтны нэрийн дансны үлдэгдэл бөгөөд эдгээр ялтнууд нь хувийн харилцах данс, банкны картгүй байна.

3.8 Аудитын гол асуудал

Шүүхийн шийдвэр гүйцэтгэх ерөнхий газрын харьяа дөрвөн зуун арван долоо дугаар нээлттэй хорих анги нь цалингийн сангаас 8,298.0 мянган төгрөгийг ахмадын санд шилжүүлж зарцуулсан нь зориулалт бус зардал бөгөөд санхүүгийн тайланд орлого болон цалингийн зардлыг бодитой бусаар нэмэгдүүлж байна.

Худалдан авалтуудыг Э-баримтаар бүрэн баримтжуулдаггүй, гэрээнд тусгадаггүй, хянаж ажилладаггүй байна.

3.9 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайлангийн аудитын санал дүгнэлтээс тусад нь салгах ёстой гэж заасан байна.

3.9.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан “Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам”-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй.

Тайлант хугацаанд оруулбал зохих 149 мэдээллээс хугацаандаа оруулсан 144 мэдээлэл, хугацаа хоцроосон 5 мэдээлэл байна.

3.9.2 Бусад хууль тогтоомжийн хүрээнд

Тус байгууллага нь санхүүгийн тайлан, аудитад шаардлагатай баримт, материалыг жагсаалт үйлдэн файлаар болон цаасаар ирүүлсэн.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим, сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн, нэмэлт санхүүжилтээр зарцуулсан хөрөнгө, үнэ төлбөргүй хүлээн авсан орлогууд бусад хууль тогтоомжийн хүрээнд нийцсэн байна гэж дүгнэлээ.

3.10 Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

Тус байгууллага 2020 оны санхүүгийн тайлангийн аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтийг 2021 оны 6 дугаар сарын 16-ны өдрийн 01/351 тоот албан бичгээр гарган ирүүлсэн байна.

3.11 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Орлогын бүртгэл, гэрээ, гэрээний хэрэгжилт, авлагын талаар дараагийн аудитаар анхаарах.

4. Аудитын илрүүлэлт

Аудитаар нийт 201,177.4 мянган төгрөгийн алдаа зөрчил илэрснээс аудитын явцад 57.8 мянган төгрөгийн зөрчлийг залруулж, 201,177.3 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага бичив.

4.1 Залруулсан алдаа

Тус байгууллага нь НДШ-ийн авлага 57.8 төгрөгийг авлагаар тусгаагүй байна. Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4-д “Нягтлан бодох бүртгэлд дараах зүйлсийг заавал бүртгэнэ”, 14.4.2-т “бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлага”, 20 дугаар зүйлийн 20.2.3-т “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 5.1.3-д жинхэнэ хэрэгжилтийн зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлнө” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “тохиолдсон байх”, “үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хангахгүй байна.

Шийдвэрлэсэн нь: Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 15 дугаар зүйлийн 15.2-т “Нягтлан бодох бүртгэлийн алдааг алдаа гарсан үеийн санхүүгийн тайланд тусгах замаар залруулна” гэсэн заалтын дагуу гүйцэтгэлийн үе шатанд залруулга хийгдсэн.

4.3 Албан шаардлага

Цалингийн сангаас 8,298.0 мянган төгрөгийг ахмадын санд шилжүүлж зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Харилцагч байгууллагатай хийсэн худалдан авалтыг /дансны хуулгын дүнг/ Татварын Е баримт, Е постын дүнтэй тулгалт хийхэд Е баримтын дүн шилжүүлсэн мөнгөн дүнгээс 185,328.5 мянган төгрөгөөр дутуу, 3,573.3 мянган төгрөгөөр илүү байна. Энэ нь Сангийн сайдын 2017 оны 347 дугаар тушаал, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.3-д “холбогдох олон улсын стандарт, эрх бүхий төрийн байгууллагаас баталсан нягтлан бодох бүртгэлийн стандарт, журам, заавар, энэ хуулийн 6 дугаар зүйлд заасан зарчмыг баримтлан нягтлан бодох бүртгэл хөтөлж, санхүүгийн тайлан гаргах” гэж заасныг болон санхүүгийн тайлангийн “нийцсэн бөгөөд зохистой байх” гэсэн батламж мэдэгдлийг хангаагүй зөрчсөн байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Зардлын эдийн засгийн ангилал зөрчиж бараа үйлчилгээний бусад зардлаас нэг удаагийн тусламж, туслах аж ахуйд 3,977.5 мянган төгрөгийг зарцуулсан нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д “батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах” гэсэн заалт, “Үнэн зөв байдал” гэсэн батламж мэдэгдлийг хэрэгжүүлж ажиллаагүй байна.

Шийдвэрлэсэн нь: Албан шаардлага хүргүүлэв.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Төв аймаг дахь Төрийн аудитын газарт 2022 оны 6 дугаар сарын 10 -ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

5. Аудитаар илэрсэн алдаа, зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

Д/д	Аудитад хамрагдсан байгууллагын нэр	Нийт алдаа зөрчил		Үүнээс							
				Залруулга		Төлбөрийн акт		Албан шаардлага		Зөвлөмж	
		Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн	Тоо	дүн
1	Хорих 417	3	201,177.3					3	201,177.3		